**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 10 өдөр Дугаар А/08 Улаанбаатар хот

Багахангай дүүргийн 2 дугаар хорооны
авто замын ус зайлуулах байгууламжийн
ажлын техникийн зураг төсөв боловсруулах зөвлөх
үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны А/39 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багахангай дүүргийн 2 дугаар хорооны авто замын ус зайлуулах байгууламжийн ажлын техникийн зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн дарга: | Д.Хүрэлбаатар | Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга |
| Гишүүд: | Б.Гэрэлмаа | Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын захирал |
| | Ж.Наранцэцэг | Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Захиргааны зохион байгуулалт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, хороо хариуцсан мэргэжилтэн |
| | П.Бор | 2 дугаар хорооны иргэн |
| Нарийн бичиг | Д.Ганчимэг | Худалдан авах ажиллагааны албаны Сургалт, шилэн данс, санхүү хариуцсан мэргэжилтэн |

2.Хууль тогтоомжийн дагуу зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Ажлын хэсэг (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

AJIL\2023 он ажил\захирамж
1123000019